# НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 02 өдөр Дугаар А/09 Улаанбаатар хот

Жендэрийн эрх тэгш байдлыг
хангах талаар баримтлах бодлогыг
хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Эрүүл Мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Эрүүл мэндийн салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар бахримтлах бодлого батлах тухай” А/625 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ТУШААХ нь:

1. Байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн тайлан, мэдээг цаг хугацаанд тайлагнаж ажиллахыг Хүний нөөц, Дотоод хяналтын ажилтан /Г.Гантуяа/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Чанарын менежер /Д.Дашдэлэг/-д даалгасугай.

ДАРГА Х.ГАНБАТ

Багахангай Эрүүл мэндийн төвийн даргын
2023 оны 03 дугаар сарын 02 -ны өдрийн
А/09 тушаалын хавсралт

БАГАХАНГАЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВӨӨС "ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ" ЧИГЛЭЛЭЭР ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хариуцсан ажилтан | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | Хамтран ажиллах байгууллага |
|---|---|---|---|---|---|
| Эрүүл мэндийн салбарт ажиллагсдын жендэрийн мэдлэг, хандлага, чадавхыг дээшлүүлэн мэргэшүүлж, жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх | | | | | |
| 1. | Дотоодын сургалтыг түшиглэн жендэрийн эрх тэгш байдлыг хангах сэдвээр сургалт зохион байгуулах | Хүний нөөц | Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан иргэдийн тоо | Ажилчдын мэдлэгийг нэмэгдүүлсэн байна. | Холбогдох байгууллага |
| Жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөв, нөөц хуваарилалт, шийдвэр гаргахад хүйсээр ангилсан бүртгэл, мэдээлэл, судалгаанд үндэслэдэг болгох | | | | | |
| 2. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний мэдээлэл, үзүүлэлтийг гаргахдаа хүйсээр ангилж гаргаж хэвшүүлэх, мэдээллийн сангийн дататай болох | Статистикч | Мэдээллийн сангийн датаг бүрдүүлсэн байна. | Мэдээллийн сантай болсон байна. | |
| 3. | Жендэрийн үр дүнг тооцох зорилгоор иргэний нас, хүйс, нийгмийн байр | НЭМ-ийн эмч | Судалгаатай болсон байна | Нэгдсэн судалгааг | Хороодтой |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | суурь, хөрөнгө чинээ, оршин суугаа газар нутаг, хөдөлмөр эрхлэлтийн хэлбэр, албан тушаал, цалин хөлсний ялгаа, гэр бүлийн хүрээн дэх байр суурь, эрх мэдэл зэрэг нийгмийн ялгаатай байдал эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгааг судлагааг гаргах. | | | төрөлжүүлэн гаргасан байна. | |
| Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын эмч, эмнэлгийн ажиллагсдын ажиллах орчин болон иргэдэд үзүүлж байгаа тусламж, үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй болгох замаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэгш боломж, чанар, хүртээмжийг сайжруулах | | | | | |
| 4. | Жендэрийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган холбогдох стандарт, заавар журмыг байгууллагын үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллах. | Хүний нөөцийн ажилтан | Журмыг судалсан байна. | Тодорхой ажлуудыг зохион байгуулсан байна. | |
| 5. | Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг тусламж үйлчилгээг үзүүлэх эрэгтэйчүүдийн кабинетийн бэлэн байдлыг хангах | Удирдлагын баг | Кабинеттай болсон байна. | Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлдэг болсон байна. | НЭМГ ДЗДТГ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6. | Эхийн эндэгдэл, жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлд нөлөөлж байгаа нийгмийн болон жендэрийн хүчин зүйлийг судлан нөлөөллийг бууруулах арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах, үр дүнг тооцож ажиллах. | НЭМ-ийн эмч | Судалгааг хийсэн байна. | Амьдралын зөв дадлыг олгох сургалтуудыг зохион байгуулсан байна. | ААНБ |
| Эмэгтэй эрэгтэйчүүдийн биологийн болон нийгмийн ялгаатай хэрэгцээг харгалзсан эрүүл мэндийн жендэрийн мэдрэмжтэй мэдээлэл, сургалт, сурталчилгааг бусад салбарын оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан хөгжүүлэх. | | | | | |
| 7. | Зонхилон тохиодож байгаа халдварт бус өвчлөлд нөлөөлж буй эрсдэлт зан үйлийг өөрчлөх эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааг хүйсийн нийгмийн ялгаатай байдалтай уялдуулан зохион байгуулах. | НЭМ-ийн эмч | Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан иргэдийн тоо | Амьдралын зөв дадлыг олгох сургалтуудыг зохион байгуулсан байна. | ААНБ |
| 8. | Архи, тамхины хэрэглээ, хөдөлгөөний хомсдол, осол гэмтэл хордлогоос сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнимй ажлыг эрчимжүүлэн ажиллах. | НЭМ-ийн эмч | Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан иргэдийн тоо | Амьдралын зөв дадлыг олгох сургалтуудыг зохион байгуулсан байна. | ААНБ |